

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2026 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 7590 дугаарт бүртгээ

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ХҮҮХЭД, ГЭР  
БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, СОЁЛ,  
УРЛАГИЙН ГАЗАР, БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН  
ХОРООНЫ ХАМТАРСАН ТУШААЛ**

2026 оны 3 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар А/59, А/74, А/15

Улаанбаатар  
хот

**ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, хүүхдийн эрхийг хамгаалах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газар, Соёл, урлагийн газрын Захиргаа удирдлагын газар, Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамир, Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс, аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн болон соёлын, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн байгууллага, газар, хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Соёл, урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хорооны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, хэлтэс, хүүхэд, соёл, спортын улсын байцаагч нарт тус тус даалгасугай.

4.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл, урлагийн газрын даргын хамтарсан “Журам батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.БАТХУЯГ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.БИЛЭГТ

*Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд,  
гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар,  
Соёл, урлагийн газар, Биеийн тамир спортын  
улсын хорооны даргын 2026 оны 3 дугаар сарын  
31-ний А/59, А/15, А/ 74 дугаар хамтарсан  
тушаалын хавсралт*

## **СОЁЛ, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙГ ОРОЛЦУУЛАХ, ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн болон бусад арга хэмжээнд оролцуулах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр, эрсдэлийн үнэлгээ хийсэн, хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхгүй орчинд оролцуулна.

1.3. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Соёлын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтална.

1.4. Соёл, спортын үйл ажиллагаа болон бусад арга хэмжээ нь холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөвлөгдсөн, орон нутгийн соёл, спорт болон хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж бүртгүүлсэн байна.

1.5. Тухайн соёл, спортын үйл ажиллагаа, уралдаан тэмцээнийг зохион байгуулахаар удирдамж баталсан төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, хувь хүнийг цаашид /Зохион байгуулагч тал/ гэх;

1.6. Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаанд хариуцан оролцуулж буй хувь хүн, хуулийн этгээд, сургууль, клуб, хөгжлийн төв, хүүхдийн ордон, багш, дасгалжуулагч, эцэг, эх, асран хамгаалагчийг цаашид /Оролцуулагч тал/ гэх;

1.7. Соёл, спортын үйл ажиллагаанаас бусад арга хэмжээнд хүүхдийн чуулган, зөвлөгөөн, цугларалт, хүүхэд оролцсон шалгалт, гадаад, дотоодод зохион байгуулагдаж буй соёл, спортын уралдаан, урлагийн тоглолт, үзүүлбэр, олимпиад, хүүхдийн хөдөлгөөн болон байгууллагын арга хэмжээ хамаарна.

1.8.Соёл, спортын үйл ажиллагаанд оролцож буй байгууллага, багш, дасгалжуулагч, ажилтан, сайн дурын ажилтан нь хүүхэд хамгааллын бодлого, ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд түүнийг мөрдөх талаар сургалтад хамрагдсан байна.

1.9.Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулагч болон оролцогч талууд хамтран ажиллана.

1.10.Зохион байгуулагч болон оролцогч талууд соёл, спортын үйл ажиллагаа, бэлтгэл сургуулилтын явцад хүүхэдтэй хүндэтгэлтэй харьцаж, биеийн төрх, үйлдлээр айлган сүрдүүлэх, үл хайхрах, гутаан доромжлох, нэр хоч өгөх, уралдаан тэмцээнд гаргасан амжилт буурсан тохиолдолд сэтгэл санааны дарамт, шахалт үзүүлэх, хүүхдийн эрх, нэр төр, алдар хүндэд сөргөөр нөлөөлөх аливаа үйлдлээс ангид ажиллана.

1.11.Хүүхдийн нэр төр, хувийн нууцад халдах, эсхүл хүүхдийг эмзэг байдалд оруулахуйц зураг, дуу, дүрс бичлэгийг хүүхэд болон түүний эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр авах, бусдад дамжуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтлэхийг хориглоно.

1.12.Хүүхэд өөрийн оюуны бүтээлч үйл ажиллагааны хүрээнд шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, зохиогчийн эрх эдлэх эрхтэй бөгөөд хүүхдийн бүтээлийг хүүхдийн болон түүний эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлах, бусдад шилжүүлэхгүй байх;

1.13.Соёл, спортын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

1.13.1.Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;

1.13.2.Ялгаварлан гадуурхахгүй, тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлэх;

1.13.3.Хүүхдийн язгуур эрх ашгийг дээдлэх;

1.13.4.Нас, хөгжлийн онцлогт нийцсэн мэргэжлийн удирдлага, заал танхим, дасгалжуулалтаар хангах;

1.13.5.Хүүхэд, гэр бүлийн хувийн мэдээлэл, нэр төрийг хамгаалах;

1.13.6.Хүчирхийллийн аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх;

1.13.7.Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, хөгжил, төлөвшилд сөрөг нөлөөгүй байх;

1.13.8.Эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт хангасан орчинд зохион байгуулах;

1.13.9.Улс төрийн болон хувийн ашиг сонирхлоос ангид байх;

### **Хоёр. Журмын хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт**

2.1.Энэхүү журмын хэрэгжилтэд хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгдсэн удирдлага,

зохицуулалтыг хэрэгжүүлж, 2.4-д заасан хугацаанд хэрэгжилтийн үнэлгээ хийж, хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

2.2. Зохион байгуулагч тал нь баталсан хөтөлбөр, удирдамжийг соёл, спорт, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагад ажлын 10 хоногийн өмнө танилцуулж, зөвшөөрөл, заавар зөвлөмж авч ажиллана.

2.3. Соёл, спортын үйл ажиллагааг зохион байгуулахдаа тухайн салбар, байгууллагын хүүхэд хамгааллын бодлого, ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.

2.4. Журмын хэрэгжилтэд орон нутагт хоёр жил тутам, үндэсний хэмжээнд гурван жил тутам хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

### **Гурав. Талуудын эрх, хүлээх үүрэг, хариуцлага**

#### **3.1. Зохион байгуулагч тал**

3.1.1. хүүхэд хамгааллын бодлого, журамтай байх бөгөөд эрх бүхий этгээдээс баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөх,

3.1.2. зохион байгуулагч тал нь соёл, спортын үйл ажиллагаа, бэлтгэл сургуулилтын өмнө болон явцад хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлийн урьдчилсан үнэлгээг хийж, илэрсэн эрсдэлийг арилгах, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.1.3. хүүхдийг байрлуулах, тээвэрлэх, бэлтгэл сургуулилт хийх болон арга хэмжээнд оролцуулахтай холбоотой аюулгүй ажиллагааны заавар, зөвлөмжийг оролцуулагч талд албан ёсоор өгч, хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар хариуцлагын гэрээ байгуулж ажиллах.

3.1.4. хөгжлийн бэрхшээлтэй, онцгой халамж, анхаарал шаардах, угсаатан, хэлний цөөнх, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх;

3.1.5. удирдамж хөтөлбөртөө цагийн хуваарийг нарийн тусгаж, хүүхдийг шөнийн үзүүлбэрт 19 цагаас хойш оролцуулахгүй байх, унаа тээвэр, байр, хоол хүнс, эмнэлэг үйлчилгээ, амралт завсарлага болон тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, эрхийг хамгаалах асуудлыг заавал тусган хүүхдэд ойлгомжтой хэлбэрээр урьдчилан түгээсэн байх;

3.1.6. хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэл, зүй бус хандлага илэрвэл таслан зогсоож, мэдээлэхийг хүүхэд тэдний асран хамгаалагч, бусад бүх талуудад таниулах;

3.1.7. хүүхдийг эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамрагдсан эсэхэд хяналт тавих;

3.1.8.хөгжлийн бэрхшээлтэй, бүтэн өнчин, асрамж халамжид амьдарч буй хүүхэд, 13 хүртэлх насны оролцогч хүүхдээс тэмцээний мандат, төлбөр хураамж авахгүй байх;

3.1.9.хууль ёсны шийдвэрээр зохион байгуулагдаж буй хурдан морины уралдааны цаг хугацаа, байршил, зам талбай, гараа барианы төхөөрөмж, хүн эмнэлэг, хүүхэд хамгааллын үйлчилгээний бэлэн байдлыг хангах, уралдааны замд урьдчилсан эрсдлийн үнэлгээ хийсэн байх;

3.1.10.хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн, хохирсон бол асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх, хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;

3.1.11.хурданморьюнахуралдаанчхүүхдийгбүртгэх,оролцуулах, аюулгүй байдлыг хангах, тусламж үзүүлэх үйл ажиллагааны стандарт шаардлагыг хангах, эрх үүрэг бүхий талуудад хяналт тавьж, эрсдлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах;

3.1.12.уралдаанч хүүхдийг үндэсний хурдан морин уралдаан, морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан нэг жилийн ослын даатгалд даатгуулсан байх, уралдааны замын нөхцөл байдалд урьдчилан үзлэг шалгалт хийх, туулах замын чиглэл, эргэлтийн цэгийн зураглал гаргаж, танилцуулах, чиглэл заасан тэмдэг тэмдэглэгээг байршуулах;

3.1.13.зохион байгуулагч болон оролцуулагч тал нь хүүхдийг өөрийн оршин суугаа газраас өөр хот, суурин газарт соёл, спортын үйл ажиллагаанд оролцуулахдаа эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байрлах байрыг урьдчилан бэлтгэсэн байх;

3.1.14.оролцогч хүүхэд тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч зэрэг үүрэг бүхий талуудад энэхүү журмыг танилцуулж, хүүхэд төөрөх, алга болохоос сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, оролцогчдыг сэрэмжлүүлэг мэдээллээр хангах;

3.1.15.хүүхдийг үе тэнгийн дээрэлхэлт, бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртөж болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдлыг үнэлж, аливаа хэлбэрээр хүчирхийлэлд өртсөн тохиолдолд сэтгэл зүйчтэй хамтран ажиллах;

3.1.16.хүүхдийг олноор нь уралдаан, тэмцээнд оролцуулахдаа удирдсан багшаас гадна эмч заавал томилон ажиллуулах;

3.1.17.хүүхдийн дэргэд архи тамхи, мансууруулах бодис хэрэглэх, хууль бус үйлдэл мөрийтэй тоглоом, мөрийцөх зэрэг хууль бус үйлдэл гаргахгүй зүй бус үг хэллэг хэрэглэхгүй байх;

## 3.2.Оролцуулагч тал

3.2.1.хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаанд оролцуулахдаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бичгээр зөвшөөрөл,

хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн байдал, харшлах хоол хүнс, хэрэглэж буй эм тариа, анхаарах зан төлвийн талаарх мэдээллийг авч, яаралтай үед холбоо барих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.2.2. хүүхдийн сургалт, хичээлийн ачааллыг харгалзан бэлтгэл сургуулилын ачааллыг тэнцвэржүүлж, шаардлага хангасан бэлтгэл сургуулилын хувцас, хэрэгсэл, заал танхимаар хангах бөгөөд хүүхдийн бие бялдар, ур чадварын бэлтгэлийг хангахдаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллана.

3.2.3. хүүхдийг үйл ажиллагаанд оролцуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 84.3-т заасан “насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30 цагаас илүүгүй байх” шаардлагыг мөрдөж, цагийн хуваарийг гаргана.

3.2.4. сургалт, уралдаан, тэмцээний дасгалжуулалтыг удирдах дасгалжуулагч, хүүхдийг асран хамгаалах багш, мэргэжилтэн нь холбогдох хууль тогтоомжид заасан мэргэжлийн зэрэгтэй, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сургалтад хамрагдсан байх бөгөөд тэдний ажлын удирдамж, гэрээнд хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүргийг тодорхой тусгасан байна.

3.2.5. хүүхэд хамгааллын бодлого, журмыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, уяач болон гэрээгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэх, хүүхэдтэй харилцах бүх талуудад танилцуулж, мөрдүүлэх арга хэмжээг авна.

3.2.6. хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаанд оролцуулах орчинд эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэхийг нягталж, хяналтын камер болон бичлэгийн хадгалалт, найдвартай байдлыг хангахыг шаардах бөгөөд хүүхэд төөрөх, алга болох, хулгайлагдах, хууртах, хүний наймаа, хөдөлмөрийн болон бэлгийн дарамт, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж, оролцогчдыг сэрэмжлүүлэг мэдээллээр хангана.

3.2.7. хүүхдийг төөрөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор багш, дасгалжуулагч, эмч, хэлмэрч зэрэг хариуцагчийн холбоо барих утас, хаягийн мэдээллийг хүүхэдэд мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд мандат, бугуйвч, хувцасны энгэрийн бичиглэл болон бусад таних тэмдгээр хангана.

3.2.8. эрүүл мэндийн хүндэтгэх шалтгааны улмаас хүүхэд тухайн үйл ажиллагаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд хүүхэд болон түүний эцэг эх, асран хамгаалагчийн гаргасан шийдвэрийг хүндэтгэнэ.

3.2.9. төлбөр, шагнал урамшуулал бүхий үйл ажиллагаанд оролцсон бол хүүхэд болон түүний эцэг эх, асран хамгаалагчтай харилцан тохиролцож, орлогын хувь хэмжээг ил тод, тэгш хуваарилна.

3.2.10. соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч

нь насанд хүрээгүй уран бүтээлчийг эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөлд ажиллуулахгүй бөгөөд зуучлагч байгууллагыг урьдчилан судалж, хүүхэд хамгааллын эрх бүхий байгууллагатай гурвалсан гэрээ байгуулсан байна.

3.2.11.уралдаанч хүүхдэд үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13.1-д заасан стандартын шаардлагад нийцсэн хувцас, хэрэглэл хэрэглүүлэх, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах бөгөөд өдөрт хоёроос дээш уралдаанд оролцуулахгүй байна.

3.2.12.хүүхдийг байрлуулах байр нь эрэгтэй, эмэгтэй хүүхдийг тус тусад нь байрлуулах зохион байгуулалттай байх ба соёл, спортын үйл ажиллагаа зохион байгуулах, хүүхэд байрлах орчинд хяналтын камертай байна.

3.2.13.хүүхэд байрлаж буй орчинд архидан согтуурах, хүчирхийлэл үйлдэх зэрэг зүй бус үйлдэл гаргахгүй байх нөхцөлийг хангаж, үүссэн тохиолдолд байр, буудлын зохион байгуулагчид мэдэгдэн даруй арга хэмжээ авч, шаардлагатай бол цагдаагийн байгууллагад мэдээлнэ.

3.2.14.сургалт, хичээлийн ачааллыг тэнцвэржүүлэн тохирсон бэлтгэл сургуулилтыг хийлгэх, шаардлага хангасан бэлтгэл сургуулилтын хувцас, заал танхимаар хангах;

3.2.15.хүүхэд асран хамгаалагч, хариуцагчтай байгуулах гэрээнд хүүхэд төөрөх, алга болох, хулгайлагдах, хууртах, хүний наймаа, хөдөлмөрийн болон бэлгийн дарамт, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, оролцогчдыг сэрэмжлүүлэг мэдээллээр хангах талаар тусгана.

3.3.Хүүхэд, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч

3.3.1.хүүхдийн өөрийн регистр, цусны бүлэг, эцэг эх, гэр бүлийн гишүүний гар утасны дугаар, гэрийн хаягаа цээжээр мэддэг байх, эрүүл мэнд, аюулгүй байдлаа эрхэмлэх, хувийн мэдээллээ хамгаалах, өөртэйгээ холбоотой шийдвэрт оролцох, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх;

3.3.2.эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн оролцох эрхийг хүндэтгэх, хүсэл, сонирхлыг харгалзан, нас, бие бялдар, сэтгэхүйн онцлогт тохирсон үйл ажиллагаанд оролцуулахыг дэмжих,

3.3.3.хүүхдийг оролцуулахдаа хичээл сургалтын тасалдал, хоцрогдлыг нөхөх арилгах, аюулгүй байдлыг хангах арга зам, санхүү төсөв зэргийг хүүхэд тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, оролцуулагч зэрэг талууд зөвшилцөн хамтын шийдвэр гаргах;

3.3.4.тухайн үйл ажиллагааны талаар урьдчилан мэдээлэл авах, зөвшөөрөл бичгээр гаргах, хэзээ хаана болох, хариуцан ажиллах багш,

дасгалжуулагч, уралдаан тэмцээн, үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбогдох бусад мэдээлэлтэй танилцах, шаардах эрхтэй.

3.3.5.хүүхдийг эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгал, үзлэг шинжилгээнд хамруулах, дүгнэлт гаргуулах;

3.3.6.хууль ёсны асран хамгаалагч нь зохих баримт бичиг, хүүхдийн хувийн бэлтгэлийг ханган хариуцагчид хүлээлгэн өгөхдөө хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал, хөгжлийн онцлог хэрэгцээг үнэн зөв мэдээлэх, буцаж ирэхэд хүлээн авах;

3.3.7.үйл ажиллагааг зохион байгуулах орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээтэй танилцах, хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байх, гэрээ байгуулахдаа хүүхдийг хөдөлмөр, эдийн засгийн болон бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх асуудлыг заавал тусгах;

3.3.8.эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн өмнөөс хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эсэн мэнд амьдрах, оролцох эрхийг зөрчих урт хугацааны гэрээ байгуулахгүй байх;

3.3.9.хүүхдэд өөрийн бие махбод, үе тэнгийн дээрэлхэлтээс ангид байх, мэдээлэх, хувийн орон зайд хэн ч халдахгүй байх, яаралтай тусламж хүсэх, аюул, эрсдэлийн үед асран хамгаалагч, багш, хүүхдийн тусламжийн утсанд мэдээлэх талаар зөвлөмж өгөх;

#### 3.4.Боловсрол, сургалтын байгууллагын эрх, үүрэг

3.4.1.хүүхэд хүсэл, сонирхлынхоо дагуу аливаа үйл ажиллагаанд оролцох эрхийг хүндэтгэх, хөгжих боломж, авьяас чадварыг эцэг эх, асран хамгаалагчтай хамтран дэмжин туслах;

3.4.2.албан ёсны төрийн байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд оролцсон хүүхдийн хичээл нөхөх, хоцрогдол арилгах асуудлыг сургуулийн захиргаа хариуцах;

3.4.3.уралдаанч хүүхдийг сургууль завсардах, хичээл хоцрогдлоос сэргийлэх, хүүхэд, уяач, эцэг эх, асран хамгаалагчтай гэрээ, хэлцэл байгуулж, үр дүнг нь мэдээлэх;

3.4.4.соёл, спортын уралдаан тэмцээнд оролцсон хүүхдийн хичээлийн тасалдал, хоцрогдлыг арилгах, цахим хичээл, сургалтад хамрагдах нөхцөл боломжийг сургууль, багшийн зүгээс бий болгох;

3.4.5.хоёр долоо хоногос дээш хугацаагаар бэлтгэл сургуулилт хийх, хичээл сургалтын цаг тасрах үед хоцрогдлыг арилгах, нөхөх арга хэмжээг оролцуулагч тал болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь сургуулийн захиргаа, сургалтын менежертэй зөвшилцөн, хүүхдэд дарамтгүй, ээлтэй байдлаар хамтран зохион байгуулах;

3.4.6.соёл спортын үйл ажиллагаанд оролцох үеэр хүүхдийн эрх ашиг хөндөгдсөн, зөрчигдсэн бол хүүхэд хамгааллын байгууллага, албан тушаалтан эсвэл тусламжийн 108 утсанд мэдээлэх, гомдол

гаргах;

3.4.7.бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь 18 хүртэлх насны хүүхдэд биеийн тамир, спортын заал, талбай, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг төлбөртэй түрээслэхгүй байх;

3.4.8.сургууль, багш өөрийн ажлын үр дүн, амжилтыг чухалчлан суралцагчийг олимпиад, уралдаан, тэмцээнд оролцох, элсэлтийн шалгалт өгөхөд хичээл болон хичээлийн тоог хязгаарлах, албадлага, дарамт шахалт үзүүлэх зэрэг зүй бус үйлдэл гаргахгүй байх;

### **Дөрөв. Хүүхдийг аюулгүй тээвэрлэх үйл ажиллагаа**

4.1.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаанд оролцуулахтай холбоотой тээвэрлэлтийг Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангаж зохион байгуулна.

4.2.Хүүхэд тээвэрлэх үйл ажиллагаанд энэхүү журмын дөрөвдүгээр бүлэг болон “Хүүхдийг аюулгүй тээвэрлэх нөхцөлийг хянах хуудас 01”-д заасан шаардлагыг заавал мөрдөнө.

4.3.Нийтийн зорчигч тээврээс бусад тээврийн хэрэгслээр хүүхдийг зорчуулах бол асран хамгаалах, хариуцах этгээд нь хүүхэд бүрийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах гэрээ байгуулж ажиллах;

4.4.Эцэг эх, асран хамгаалагч хувийн унаагаар хүүхдээ тээвэрлэх үед багш, дасгалжуулагчийн зааврыг мөрдөн аюулгүй тээвэрлэлтийн шаардлагыг ханган, зуны улиралд 20 цаг, өвлийн улиралд 18 цагаас хойш тээвэрлэхгүй байх;

4.5.Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598 стандартын 8-р зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан байх;

4.6.Хүүхдийг авто машинаар аюулгүй тээвэрлэхэд Хүүхэд тээвэрлэх автобус үйлчилгээнд тавигдах шаардлага MNS6440:2014, замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх;

4.7.Жолооч тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг ханган цаг агаарын аюултай нөхцөлд хариуцлагатай, анхаарал болгоомжтой байх;

4.8.Хүүхдийг нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 23.6, 23.7, 23.8 дахь хэсэгт заасны дагуу аюулгүй байдлыг ханган тээвэрлэх;

4.9.Оролцуулагч тал нь очих газрын км, цаг агаарын нөхцөлийг тооцон хууль тогтоомжид зааснаар хүүхдийн түр амрах, буудаллах цэг, хоноглох газар орчинг тооцож бэлтгэсэн байх;

4.10.Хөдөлгөөн эхлэхийн өмнө ачаа тээшийг зохих орчинд байрлуулж, хүүхдийг зориулалтын суудалд суулган, хамгаалах бүсийг зүүлгэх, хөдөлгөөн эхэлснээс хойш босож явахгүй байх талаар заавар

зөвлөгөө өгөх;

4.11.Жолооч нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 23 дахь хэсэгт заасан “Хүн тээвэрлэх” нөхцөлийг хангах, суудлын тооноос хэтрүүлэх, зорчигчийн танхим, бүхээгт хүүхэд байх үед автобус, машиныг эзгүй орхих, хөдөлгөөний үед огцом тооромслох, хурдны дээд хязгаар хэтрүүлэх, тамхи татах, согтууруулах, мансууруулах төрлийн зүйл хэрэглэхийг хориглох;

4.12.Хүүхэд тээвэрлэх явцад техникийн саатал гарвал холбогдох талуудад яаралтай мэдэгдэж, дараагийн тээврийн хэрэгсэл иртэл хүүхдийн аюулгүй байдлыг хангах;

4.13.Хүүхдийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулах ба тээвэрлэгч нь гэрээгээр тогтоосон зам, цагийн хуваарийн дагуу "Хүүхэд тээвэрлэж байна" анхааруулгын тэмдэг бүхий тээврийн хэрэгслээр аюулгүй тээвэрлэх;

### **Тав. Олон улс, тив дэлхийн соёл, спортын уралдаан тэмцээнд хүүхэд оролцуулах үйл ажиллагаа**

5.1.Талууд хүүхдийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахдаа хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн бичгээр эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим зөвшөөрлийг авч, ажиллах цаг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тодорхой тусган Хүүхдийн эрхийн улсын байцаагч тухайн тохиолдолд зөвшөөрөл олгосон бол Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр оролцуулж болно.

5.2.Эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийг хариуцагч багш, дасгалжуулагч, хүүхдийн байгууллага, Хүүхдийн эрхийн улсын байцаагч нар хүүхэд хамгаалал, аюулгүй байдлыг хангах гурвалсан гэрээ байгуулж, хүүхэд хамгааллын зохих зүйл заалтыг тусгах бөгөөд эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бичгээр зөвшөөрөл авах, хүүхдийг амь насны даатгалд хамруулна.

5.3.Гадаад улс оронд болох арга хэмжээнд хүүхдийг оролцуулах эцэг эх, гэр бүл санал хүсэлтээ хүүхэд, гэр бүлийн болон соёлын, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд урьдчилан мэдэгдэж, бүртгүүлэн эрсдэлээс сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл авч, тухайн орны соёл, байгаль, цаг уур, хоол хүнс, байр, тээвэр, зардал санхүүжилт, хүүхэд хамгааллын дүрэм, журамтай холбоотой мэдээлэлтэй танилцсан байх;

5.4.Хүүхдийг улс, аймаг, сум, дүүрэг, сургуулийн нэрийн өмнөөс олон улс, тив дэлхийн уралдаан тэмцээнд оролцуулж байгаа бол замын зардал, тэмцээний төлбөр хураамжийг оролцуулагч тал эцэг эх, харилцан тохиролцон хариуцах ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

бол Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журамд заасны дагуу олгоно.

**Зургаа. Журмын хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлага**

6.1. Энэхүү журмын хэрэгжилтэд бүх шатны Засаг дарга, хүүхдийн, соёлын болон биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн салбарын Улсын байцаагч, Хүүхдийн эрхийн улсын байцаагч хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавьна.

6.2. Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах явцад хүүхдийн эрх зөрчигдсөн тухай гомдол, мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд өөрөө, зохион байгуулагч болон оролцуулагч тал Хүүхдийн тусламжийн утас 108, Хүүхдийн эрхийн улсын байцаагчид заавал мэдээлнэ.

6.3. Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг эрх бүхий албан тушаалтан хүлээн авч, Хүүхдийн эрхийн улсын байцаагч болон холбогдох байгууллага шалган шийдвэрлэнэ.

6.4. Энэхүү журам, холбогдох хууль тогтоомж, гэрээ хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол буруутай этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

*2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 1-р хавсралт*

**ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ ТЭЭВЭРЛЭХ НӨХЦӨЛИЙГ ХЯНАХ ХУУДАС  
01**

Энд хүүхдийг аюулгүй тээвэрлэх бодлого, журам, хувь хүний байдал, бусад хүчин зүйлсийг анхаарсан бөгөөд тухайн онцлогоос хамаарч нэмж болно.

I.Замд гарахын өмнө	Хангалттай эсэх тэмдэглэл	Хянасан хүний гарын үсэг, тэмдэг
1.1.Жолооч нь “Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага” MNS 4598:2011 стандартад нийцсэн үнэмлэхтэй, тухайн ангиллын автомашин жолоодоход тохирч буй эсэх		
1.2.Тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 23.5-23.8 д заасан шаардлагад тохируулсан эсэх		
1.3.Хүүхдийг авто машинаар тээвэрлэх үед хүүхдийг хариуцагч багш, дасгалжуулагч анхны тусламж үзүүлэх сургалтад хамрагдсан байх		
1.4.Тухайн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхдээ зорчигч хүүхдийн эцэг эхийн зөвшөөрөл авсан байх		
1.5.Тээврийн хэрэгсэл нь аюулгүй байдлын шаардлага хангасан, техникийн үзлэгт хамрагдсан эсэх		
1.6.Хүүхдийг тээвэрлэхдээ “Хүүхэд тээвэрлэх автобус үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартын дагуу дараах зүйлийг бүрдүүлсэн байна. ҮҮНД: <ul style="list-style-type: none"><li>• Яаралтай үед мэдээлэл дамжуулах цэнэгтэй гар утас, холбооны хэрэгсэл;</li><li>• Хүүхдийн яаралтай холбоо барих хаяг, утасны дугаарын мэдээллийг бүртгэлжүүлэх;</li><li>• Онцгой байдал, осол, гэмтлийн үеийн яаралтай тусламжийн хэрэгсэл, нарнаас хамгаалах сүүдрөвч;</li><li>• Хүүхдийг аюулгүй тээвэрлэх зааварчилгаа</li><li>• Тээврийн хэрэгслийн хяналтын хуудас;</li><li>• Үзэгдэх орчин сайтай хантааз, бамбар;</li><li>• Аюулгүй хүнс, ундны ус, усны нөөц сав;</li><li>• Тээврийн хэрэгслийн гүйлтийн заалт, бодит бүртгэл</li></ul>		
1.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тээвэрлэхдээ зориулалтын бариул, агааржуулах системтэй байна.		

II. Хүүхдийг өөр өөр газраас цуглуулах үед		
• Цуглах байршилд ойр газар замын нэг талд тээврийн хэрэгслийг байрлуулах		
• Хүүхдийг тээврийн хэрэгсэлд суулгахдаа аюулгүй байдлыг хангасан зогсоолд цугларахыг зарлах		
• Хүүхдийг гэрээс нь авахад эцэг эх, асран хамгаалагч хүүхэд хүлээлгэн өгсөн бүртгэлд гарын үсэг зурах		
• Хүүхдийн ирцийг ирвэл зохих ирцийн бүртгэлтэй тулган ирсэн огноо, цагийг тэмдэглэх		
• Хүүхдийг нас, биеийн хэмжээнд тохирсон суудалд суулган, ачаа тээшийг зориулалтын газарт байрлуулах		
• Хүүхдийг хүлээн авсан газраас хөдлөх тээврийн хэрэгслийн цагийг тэмдэглэх		
III. Тээврийн хэрэгслээр зорчих хөдөлгөөн эхэлсэн үед		
• Хариуцагч багш дасгалжуулагчийн зөвлөгөөг дагаж мөрдөх		
• Хүүхэд бүрийн аюулгүй зорчих байдлыг үргэлж хянаж байх		
• Аян замын турш тодорхой зайд аюулгүй байдлыг хянах, урьдчилан тооцож, тодорхойлсон буудаллах цэгт хүүхдийг бие засах, амрах, ундлах нөхцөлөөр хангах		
• Хоёр цаг тутам 15 минут амрах нөхцөлөөр хангах		
IV. Хүүхдийг тээвэрлэж дуусахад		
• Хүүхдийг хүргэх байршилд аль болох ойрхон зогсох;		
• Хүүхдийг тээврийн хэрэгслээс буулгах үед дахин шалган цаг, хугацааг тэмдэглэх;		
• Ирцийн бүртгэлийн дагуу хүүхдийг бүртгэн тулгаж, эцэг эх, асран хамгаалагчид хүлээлгэн өгч гарын үсгээр баталгаажуулах		
• Хүүхдийг гараас гарт хүлээлгэн өгөх		

Жич: Хянах хуудсыг хүүхдийн асран хамгаалагч, хариуцагч талуудын төлөөлөл хамтран хянаж дүгнэнэ

*2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 2-р хавсралт*

## **ХҮҮХЭД ОРОЛЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ**

### **Нэг. Зорилго**

Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлэх, үнэлэх, бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлоход энэхүү аргачлалын зорилго оршино.

### **Хоёр. Эрсдэлийн үнэлгээ хийх үе шат**

Эрсдэлийн үнэлгээг дараах дарааллаар хийнэ:

1. Үйл ажиллагааны орчныг тодорхойлох
2. Болзошгүй аюул, эрсдэлийг илрүүлэх
3. Эрсдэлийн түвшинг үнэлэх
4. Эрсдэлийг бууруулах арга хэмжээ төлөвлөх
5. Хариуцах хүнийг томилох
6. Хяналт, дахин үнэлгээ хийх

### **Гурав. Эрсдэлийг ангилал**

Эрсдэлийг дараах үндсэн төрлөөр ангилна:

№	Эрсдэлийн төрөл
1	Биеийн гэмтэл, бэртэл
2	Зам тээврийн осол
3	Гал түймэр
4	Хүүхэд төөрөх, алга болох
5	Хүчирхийлэл, дарамт
6	Хоолны хордлого
7	Халдварт өвчин
8	Байгалийн гамшиг
9	Сэтгэл зүйн дарамт
10	Хөдөлмөрийн мөлжлөг
11	Бэлгийн мөлжлөг
12	Танихгүй хүн дагаж явах, хууртах
13	Интернэт, цахим орчны эрсдэл
14	Байрлах байрны аюулгүй байдал
15	Спортын тоног төхөөрөмжийн эвдрэл

### Дөрөв. Эрсдэлийн түвшин үнэлэх арга

Эрсдэлийг магадлал, хор уршиг гэсэн үнэлгээгээр тодорхойлно.

Магадлал

Үнэлгээ	Тайлбар
1	Маш бага
2	Бага
3	Дунд
4	Өндөр
5	Маш өндөр

Хор уршиг

Үнэлгээ	Тайлбар
1	Хөнгөн
2	Бага
3	Дунд
4	Хүнд
5	Маш хүнд

Эрсдэлийн түвшин = Магадлал × Хор уршиг

Оноо	Эрсдэлийн түвшин	Арга хэмжээ
1–5	Бага	Хяналт тавина
6–10	Дунд	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна
11–15	Өндөр	Тусгай арга хэмжээ авна
16–25	Маш өндөр	Үйл ажиллагааг зогсооно

### Тав. Эрсдэлийн үнэлгээний маягтын загвар

№	Болзошгүй эрсдэл	Магадлал	Хор уршиг	Оноо	Эрсдэлийн түвшин	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах хүн
1	Хүүхэд төөрөх	3	4	12	Өндөр	Бугуйвч зүүлгэх, багш хариуцуулах	Дасгалжуулагч
2	Бэртэл гэмтэл	3	3	9	Дунд	Эмч ажиллуулах	Эмч
3	Зам тээврийн осол	2	5	10	Дунд	Баталгаат тээвэр	Зохион байгуулагч

### Зургаа. Заавал авах аюулгүй байдлын арга хэмжээ

Үйл ажиллагаа зохион байгуулагч дараах арга хэмжээг заавал авна:

- Эрсдэлийн үнэлгээ хийсэн байх

- Эмч, эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэлтэй байх
- Хүүхэд бүрийн бүртгэл, холбоо барих мэдээлэлтэй байх
- Хүүхэд таних тэмдэгтэй байх (бугуйвч, мандат)
- Хяналтын камертай байх
- Галын гарц, галын хор бэлэн байх
- Хүүхдийг насанд хүрсэн хүн хариуцах
- Эрэгтэй, эмэгтэй хүүхдийг тусад нь байрлуулах
- Баталгаат тээврийн хэрэгсэл ашиглах
- Хоол хүнсний аюулгүй байдлыг хангах

### **Долоо. Эрсдэлийн үнэлгээг хэзээ хийх вэ**

Дараах тохиолдолд эрсдэлийн үнэлгээ заавал хийнэ:

Үйл ажиллагаа	Эрсдэлийн үнэлгээ
Уралдаан тэмцээн	Заавал
Аялал, зугаалга	Заавал
Спортын бэлтгэл	Заавал
Тоглолт, зураг авалт	Заавал
Олон улсын арга хэмжээ	Заавал
Байрлаж хоноглох	Заавал
Морин уралдаан	Заавал

### **Найм. Хариуцлага**

- Эрсдэлийн үнэлгээ хийгээгүй бол үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.
- Эрсдэлийн үнэлгээг байгууллагын дарга баталгаажуулна.
- Эрсдэлийн үнэлгээг тухайн арга хэмжээ эхлэхээс 3–7 хоногийн өмнө хийсэн байна.

### **Ес. Журмын хавсралт**

I.Хавсралт 1 хүүхдийн аюулгүй тээвэрлэх нөхцөлийг хянах хуудас  
01

II.Хавсралт 2 хүүхэд оролцох үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал

III.Хавсралт 3 эрсдэлийн үнэлгээний нэгдсэн маягт

IV.Хавсралт 4 хүүхэд хүлээлцэх хуудас

V.Хавсралт 5 эцэг эхийн зөвшөөрлийн маягт

VI.Хавсралт 6 гурвалсан гэрээ

VII.Хавсралт 7 хүүхдийн бүртгэлийн маягт

VIII.Хавсралт 8 осол, зөрчлийн бүртгэлийн хуудас

IX.Хавсралт 9 аюулгүй ажиллагааны заавар

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 3-р хэвсрэлт

## ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН МАЯГТ

Байгууллагын нэр: \_\_\_\_\_  
Үйл ажиллагааны нэр: \_\_\_\_\_  
Үйл ажиллагааны чиглэл: (соёл, спорт, аялал, сургалт, уралдаан, бусад)  
Зохион байгуулах газар: \_\_\_\_\_  
Хугацаа: \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_ өдөр  
Оролцогч хүүхдийн тоо: \_\_\_\_\_  
Хариуцсан ажилтан: \_\_\_\_\_

### А.Орчны урьдчилсан үнэлгээ

	Шалгуур	хангалттай	хангалтгүй	сайжруулах	Тайлбар
А. Аюулгүй байдлын зэрэг					
1	Хүүхэд хүлээн авах бэлэн байдал				
2	Камержуулалт				
3	Хүүхэд хамгааллын бодлого				
4	Хувцас солих өрөө				
5	Бага насны хүүхэд эцэг эхтэй байх боломж				
6	Ажилтнууд ёс зүйн дүрэмтэй танилцдаг эсэх				
7	Харуул хамгаалалт				
8	Дүрэм журам				
9	Анхны тусламж үзүүлэх боломжтой эсэх				
10	Хүүхэд хамгааллын сургалт				
11	Хувийн мэдээлэл хамгаалалт				
	ДҮГНЭЛТ, САНАЛ				
Б. Барилга, байгууламж					
12	Байр зориулалтын				
13	Камерын хэвийн ажиллагаа				
14	Цахилгаан, тоног төхөөрөмж				
15	Галын хор, аврах гарц, аврах шат, хаалга				
16	Хаалга, цонх				

17	Ариун цэвэр, эрүүл ахуй, агааржуулалт				
18	Ариутгал цэвэрлэгээ				
19	Аюултай бодис хадгалалт				
<b>В. Үйл ажиллагааны орчинд</b>					
20	Эрсдэлийн хийсэн эсэх				
21	Орчны ойролцоо архи, согтууруулах ундаа худалдах, шөнийн үйл ажиллагаа явуулдаг эсэх				
22	Үйлчилгээнд 18-с дээш насны сайн дурын ажилтан ажилладаг эсэх				
23	Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм мөрддөг эсэх				
24	Хоол хүнс үйлдвэрлэлийн эрүүл, аюулгүй байдал				
25	Өрөө тасалгааны зөөлөн, хатуу эдлэл цэвэр, аюулгүй, хэрэгцээ хангах, хүртээмжтэй байдал				
26	Өрөө, тасалгааны, амралт, унтлагын цагийн хуваарь зохион байгуулалт				
<b>ҮНЭЛГЭЭ</b>					

### 1. УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ:

1	Хэвийн	
2	Сайжруулах шаардлагатай	
3	Эрсдэлтэй	

### 2. ЭРСДЭЛИЙН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ (оноогоор)

№	Болзошгүй эрсдэл	Магадлал (1–5)	Хор уршиг (1–5)	Оноо	Эрсдэлийн түвшин	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах хүн
1	Хүүхэд төөрөх						
2	Бэртэл гэмтэл						
3	Зам тээврийн осол						
4	Хоолны хордлого						
5	Хүчирхийлэл						
6	Гал түймэр						

7	Халдварт өвчин						
---	----------------	--	--	--	--	--	--

Эрсдэлийн түвшин = Магадлал × Хор уршиг

Оноо	Түвшин	Арга хэмжээ
1–5	Бага	Хяналт тавих
6–10	Дунд	Урьдчилан сэргийлэх
11–15	Өндөр	Сайжруулах шаардлагатай
16–25	Маш өндөр	Үйл ажиллагааг зогсоох

### 3.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дүгнэлт	Тэмдэг
Үйл ажиллагаа явуулах боломжтой	<input type="checkbox"/>
Сайжруулсны дараа боломжтой	<input type="checkbox"/>
Боломжгүй	<input type="checkbox"/>

Авах арга хэмжээ:

.....

.....

.....

.....

### 4. БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаал

Нэр

Гарын үсэг

Огноо

Эрсдэлийн үнэлгээ хийсэн

Зохион байгуулагч

Хүүхэд хариуцагч:

Байгууллагын удирдлага

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 4-р хэвсрэлт

### ХҮҮХЭД ХҮЛЭЭЛЦЭХ ХУУДАС

\_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_ өдөр

БАЙГУУЛЛАГЫН НЭР: \_\_\_\_\_

1. Эцэг эх / асран хамгаалагч

Нэр: \_\_\_\_\_

Регистр: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

2. Хүлээн авагч (багш/дасгалжуулагч)

Нэр: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Дараах хүүхдийг хүлээлцэв:

ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ:

Овог нэр: \_\_\_\_\_

Нас: \_\_\_\_\_

Сургууль: \_\_\_\_\_

ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЭЛ:

- Харшилтай
  - Эм хэрэглэдэг
  - Онцгой анхаарах зүйл:
- \_\_\_\_\_

ХҮҮХДИЙГ:

- Эрүүл, хэвийн байдалтай
- Тодорхой нөхцөлтэй (тайлбар): \_\_\_\_\_

ТАЛУУД ХАРИЛЦАН ТОХИРОЛЦСОН:

- Хүүхдийн аюулгүй байдлыг хүлээн авагч бүрэн хариуцна.
- Үйл ажиллагаа дууссаны дараа хүүхдийг эцэг эхэд буцаан хүлээлгэн өгнө.

ГАРЫН ҮСЭГ:

Эцэг эх: \_\_\_\_\_

Хүлээн авагч: \_\_\_\_\_

*2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 5-р хавсралт*

## **ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ**

**ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ**

Би \_\_\_\_\_ (нэр)

Регистр № \_\_\_\_\_

Миний хүүхэд:

Овог нэр: \_\_\_\_\_

Нас: \_\_\_\_\_

Дараах үйл ажиллагаанд оролцохыг **ЗӨВШӨӨРЧ БАЙНА**.

**ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

\_\_\_\_\_

**ХААНА:**

\_\_\_\_\_

**ХУГАЦАА:**

\_\_\_\_\_

Би дараах нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна:

- Хүүхэд аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.
  - Хүүхдийн эрүүл мэндийн мэдээллийг үнэн зөв өгсөн.
  - Яаралтай үед эмнэлгийн тусламж авахыг зөвшөөрч байна.
  - Хүүхдийн зураг, бичлэгийг үйл ажиллагаанд ашиглахыг зөвшөөрнө
- Зөвшөөрөхгүй /доогуур зурах/**

**ЯАРАЛТАЙ ҮЕД ХОЛБОО БАРИХ:**

Утас: \_\_\_\_\_

**ГАРЫН ҮСЭГ:**

\_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 6-р хавсралт

## ГУРВАЛСАН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

\_\_\_ он \_\_\_ сар \_\_\_ өдөр

Нэг талаас:

БАЙГУУЛЛАГА: \_\_\_\_\_

Нөгөө талаас:

ЭЦЭГ ЭХ / АСРАН ХАМГААЛАГЧ: \_\_\_\_\_

Гурав дахь тал:

ХҮҮХЭД: \_\_\_\_\_

Дараах нөхцөлөөр гэрээ байгуулж байна.

-----

### 1. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

Хүүхдийг аюулгүй, эрсдэлгүй орчинд үйл ажиллагаанд оролцуулах.

-----  
-----

### 2. БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

- Хүүхдийн аюулгүй байдлыг хангах
- Эрсдэлийн үнэлгээ хийх
- Эмч, хамгаалалттай байх
- Хүүхдийг хариуцах ажилтан томилох

-----

### 3. ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ

- Хүүхдийн үнэн зөв мэдээлэл өгөх
- Дүрэм журмыг мөрдүүлэх
- Хүүхдээ цаг тухайд нь хүлээлгэн өгөх, авах

-----

#### 4. ХҮҮХДИЙН ҮҮРЭГ

- Дүрэм, заавар мөрдөх
  - Багш, зохион байгуулагчийн зааврыг дагах
- 

#### 5. ХАРИУЦЛАГА

- Гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 

#### 6. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА \_\_\_\_ оноос \_\_\_\_ он хүртэл

-----

#### ГАРЫН ҮСЭГ:

Байгууллага: \_\_\_\_\_

Эцэг эх: \_\_\_\_\_

Хүүхэд: \_\_\_\_\_

*2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 7-р хавсралт*

### **ХҮҮХДИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ**

БАЙГУУЛЛАГЫН НЭР: \_\_\_\_\_

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭР: \_\_\_\_\_

ХУГАЦАА: \_\_\_\_\_

№	Хүүхдийн овог нэр	Нас	Хүйс	Сургууль	Эцэг эхийн нэр	Утас	Эрүүл мэндийн мэдээлэл	Гарын үсэг
1								
2								
3								

Тайлбар:

- Харшил:
- Эм хэрэглэдэг эсэх:
- Онцгой анхаарах зүйл:

Хариуцсан багш/дасгалжуулагч: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 8-р хавсралт

## ОСОЛ, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

БАЙГУУЛЛАГЫН НЭР: \_\_\_\_\_

### ОСОЛ, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ

1. Осол, зөрчил гарсан огноо, цаг: \_\_\_\_\_

2. Гарсан газар: \_\_\_\_\_

3. Осол, зөрчилд өртсөн хүүхдийн мэдээлэл:

Овог нэр: \_\_\_\_\_

Нас: \_\_\_\_\_

Сургууль: \_\_\_\_\_

4. Осол, зөрчлийн төрөл:

Бэртэл гэмтэл

Хүүхэд төөрсөн

Хоолны хордлого

Хүчирхийлэл

Зам тээврийн осол

Бусад: \_\_\_\_\_

5. Осол, зөрчлийн нөхцөл байдлын тайлбар:

\_\_\_\_\_

6. Авсан арга хэмжээ:

Анхны тусламж үзүүлсэн

Эмнэлэгт хүргэсэн

Эцэг эхэд мэдэгдсэн

Цагдаад мэдэгдсэн

Бусад: \_\_\_\_\_

7. Хариуцсан ажилтан:

Нэр: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн  
А/59, А /15, А/74 дүгээр тушаал Соёл, спортын үйл  
ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг  
хамгаалах журмын 9-р хавсралт

## ХҮҮХЭД ОРОЛЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

### Нэг. Нийтлэг шаардлага

1. Хүүхэд бүр багш, дасгалжуулагчийн зааврыг дагаж мөрдөнө.
2. Хүүхэд ганцаараа явахыг хориглоно.
3. Таних тэмдэг, бугуйвчийг байнга зүүнэ.
4. Аюултай тоног төхөөрөмжид зөвшөөрөлгүй хүрэхгүй.
5. Гэмтэл, өвдөлт, асуудал гарвал багшид нэн даруй мэдэгдэнэ.

### Хоёр. Хориглох зүйл

1. Танихгүй хүн дагаж явах
2. Зөвшөөрөлгүй байрнаас гарах
3. Цахилгаан хэрэгсэл оролдох
4. Зодоон хийх, бусдыг дээрэлхэх
5. Архидан согтуурах, тамхи татах (том хүн)

### Гурав. Онцгой нөхцөлд

1. Гал гарвал аврах гарцаар гарна.
2. Хүүхэд төөрвөл нэг газраа зогсож багшийг хүлээнэ.
3. Бэртэл гэмтэл гарвал анхны тусламж авна.

### Дөрөв. Хариуцлага

Энэхүү зааврыг зөрчсөн тохиолдолд холбогдох журмын дагуу арга хэмжээ авна.

### ЗААВАРТАЙ ТАНИЛЦСАН:

№	Нэр	Гарын үсэг
1		
2		
3		

**МОНГОЛ УЛС**  
**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ**  
**ХОРООНЫ ТОГТООЛ**

2026 оны 4 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

**ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Санал асуулгыг ажиглах, сурвалжлах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны сонгуулийн байгууллагад, сурталчлан таниулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Бат-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

3.Журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, нийтэд мэдээлэх арга хэмжээг зохион байгуулахыг Тамгын газрын Хуулийн газар (Т.Наранбат)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ДАВАА-ОЧИР

*Сонгуулийн ерөнхий хорооны  
2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн  
06 дугаар тогтоолын хавсралт*

**АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫГ АЖИГЛАХ,  
СУРВАЛЖЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмаар ард нийтийн санал асуулгын санал авах, санал тоолох, дүн гаргах /цаашид “Санал асуулга” гэх/ ажиллагаанд хөндлөнгийн ажиглалт хийх болон сурвалжлах үйл ажиллагаа, түүнд тавих хяналттай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн дагуу иргэний саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар авах болон сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах ажиллагааг ажиглах, сурвалжлахад энэ журмыг мөрдөнө.

1.3.Санал асуулгыг ажиглах, сурвалжлахтай холбоотой энэ журмаар зохицуулагдаагүй харилцааг Ард нийтийн санал асуулгын тухай хууль болон сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

1.4.Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 7.7-д заасны дагуу санал асуулгыг Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай хамтатган явуулах тохиолдод санал асуулгыг ажиглахад сонгууль ажиглах нийтлэг журмыг мөрдөнө.

**Хоёр.Ажиглагч, сурвалжлагчийг бүртгэх, үнэмлэх олгох**

2.1.Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 17.1-д заасны дагуу ажиглагч нь дараах этгээд байна:

2.1.1.Монгол Улсын болон гадаад улсын иргэн;

2.1.2.Монгол Улсад бүртгэлтэй улс төрийн нам, төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдагаас бусад нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага;

2.1.3.гадаад улсын төрийн болон төрийн бус байгууллага, улс төрийн нам;

2.1.4.Олон улсын гэрээний тухай хуулийн 3.1.6-д заасан олон улсын байгууллага болон гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар.

2.2.Энэ журмын 2.1.2, 2.1.3, 2.1.4-т заасан этгээд нь төлөөлөгчөөр дамжуулан санал асуулгыг ажиглах бөгөөд ажиглагчаар 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын болон гадаад улсын

иргэнийг томилно.

2.3.Санал авах ажиллагааг олон улс, гадаад улсын болон дотоодын хэвлэл мэдээллийн байгууллагаас томилсон сэтгүүлч энэ журмын дагуу бүртгүүлсний үндсэн дээр сурвалжилна.

2.4.Ажиглагчаар ажиллах хүсэлтийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө дараах журмаар гаргана:

2.4.1.бие даан ажиглалт хийх Монгол Улсын иргэн болон энэ журмын 2.1.2-т заасан этгээд хүсэлтээ Хэсгийн хороонд;

2.4.2.бие даан ажиглалт хийх гадаад улсын иргэн болон энэ журмын 2.1.3, 2.1.4-т заасан этгээд хүсэлтээ гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлуулан Сонгуулийн ерөнхий хороонд.

2.4.3.гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглах хүсэлтийг Төв комисст.

2.5.Санал авах ажиллагааг сурвалжлах сэтгүүлч ажиллуулах дотоодын хэвлэл мэдээллийн байгууллага хүсэлтээ шууд, олон улсын болон гадаад улсын хэвлэл мэдээллийн байгууллага хүсэлтээ гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлуулан Сонгуулийн ерөнхий хороонд энэ журмын 2.4-т заасан хугацаанд тус тус гаргана.

2.6.Ажиглагч, сэтгүүлчээр бүртгүүлэх хүсэлтийг бичгээр, эсхүл цахимаар гаргаж болох бөгөөд дараах баримт бичгийг хавсаргасан байна:

2.6.1.байгууллагын албан хүсэлт, ажиглагч, сэтгүүлч томилсон шийдвэр;

2.6.2.тухайн хүсэлт гаргасан, эсхүл томилогдсон иргэнийг тодорхойлох баримт бичгийн хуулбар (Монгол Улсын иргэн бол иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн бол паспортын хуулбар);

2.6.3.сүүлийн 3 сарын дотор авахуулсан 3\*4 хэмжээтэй цээж зураг.

2.7.Хүсэлтэд ажиглагч, сэтгүүлчээр ажиллах хүний овог, нэр, нас, хүйс болон иргэний харьяалал, одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал, төлөөлж байгаа улс болон байгууллагын талаарх мэдээллийг тусгана. Хэрэв гадаадын ажиглагч, сэтгүүлч нь орчуулагч ажиллуулах бол энэ талаар хүсэлтэд тодорхой дурдаж, тухайн орчуулагчаар ажиллах хүний иргэний үнэмлэх, орчуулагч болохыг тодорхойлсон баримт бичгийн хуулбар, сүүлийн 3 сарын дотор авахуулсан 3\*4 хэмжээтэй цээж зургийг хавсаргасан байна.

2.8.Цахим хүсэлтийг бүртгэл хийх эрх бүхий байгууллагаас нийтэд зарласан цахим хаягт ирүүлнэ. Цахим хүсэлтийг Монгол Улсын иргэн болон энэ журмын 2.1.2-т заасан этгээд гаргаж байгаа бол цахим

гарын үсгээр, гадаад улсын иргэн болон энэ журмын 2.1.3, 2.1.4-т заасан этгээд гаргаж байгаа бол өөрийн албан цахим хаягнаас илгээн баталгаажуулна.

2.9.Хүсэлтийг энэ журмын 2.4, 2.5-д заасан харьяаллын дагуу хүлээн авч хянан бүртгэж, “Ажиглагч”, “Сурвалжлагч” гэсэн үнэмлэхийг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө олгоно.

2.10.Орчуулагчийг ажиглагч, эсхүл сурвалжлагчтай хамт бүртгэж, энэ журмын 2.9-д заасан хугацаанд “Орчуулагч” гэсэн үнэмлэхийг олгоно. Ажиглагч, сэтгүүлчийн орчуулагч нь зөвхөн орчуулга хийх үүрэгтэй байна.

2.11.Ажиглагч, сэтгүүлчээр ажиллах гадаад улсын иргэн, гадаад улсын болон олон улсын байгууллагаас томилсон төлөөлөгч нь үйл ажиллагааныхаа зорилгын дагуу Монгол Улсын зохих ангилалын виз авсан байна.

2.12.Энэ журмын 2.4-т заасан хугацаанаас хоцорч ирүүлсэн хүсэлтийг хүлээн авахгүй.

### **Гурав. Ажиглагч, сурвалжлагчийн эрх, үүрэг**

3.1.Ажиглагч нь дараах эрхтэй байна:

3.1.1.санал бэлтгэх бүхээг, саналын хайрцаг, санал авах байр, зөөврийн битүүмжлэгдсэн саналын хайрцаг болон санал тоолох төхөөрөмж хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;

3.1.2.санал авах, тоолох, дүн гаргах болон иргэний саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар авах, сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах ажиллагааг ажиглах;

3.1.3.саналын хуудасны битүүмжлэгдсэн байдал болон зарцуулалтын тайлантай танилцах;

3.1.4.санал авах үйл явцад зөрчил гарвал Хэсгийн хороонд мэдэгдэж, залруулах хүсэлт тавих;

3.1.5.саналаа нууцаар гаргах иргэний эрх болон сонгуулийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан баримтжуулалт хийх;

3.1.6.Хэсгийн хорооны гишүүнээс холбогдох мэдээлэл авах, цахим хэлбэрээр хуулбарласан саналын хуудасны зурган мэдээлэл, санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас авах;

3.1.7.ажиглалтын тайлангаа олон нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх.

3.2.Ажиглагч нь дараах үүрэгтэй байна:

3.2.1.Ард нийтийн санал асуулгын тухай хууль болон сонгуулийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх;

3.2.2.сонгуулийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй, иргэдийн санал өгөх ажиллагаанд аливаа хэлбэрээр саад

учруулахгүй байх;

3.2.3. сонгуулийн байгууллага, эрх бүхий этгээдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

3.3. Ажиглагч нь хуульд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулах зэрэг хууль бус арга хэрэглэж сонгуулийн байгууллагын ажилд хөндлөнгөөс оролцох, санал асуулгаар тавигдаж байгаа асуудлаар сурталчилгаа хийх, түүнтэй холбоотой аливаа хууль бус үйлдэл, үйл ажиллагаа явуулах, иргэнээс сонголтынх нь талаар асууж ярилцахыг хориглоно.

3.4. Санал асуулгыг сурвалжлах үеэр сэтгүүлч нь энэ журмын 3.1, 3.2-т заасан эрх, үүрэг, 3.3-т заасан хориглолтыг дагаж мөрдөхөөс гадна санал асуулгын үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүргийг хүлээнэ.

3.5. Ажиглагч, сэтгүүлчийн эрх, үүрэг нь энэ журмын дагуу бүртгэж, үнэмлэх олгосноор эхэлж, санал асуулгын дүн гарснаар дуусгавар болно.

3.6. Энэ журмын 2.4, 2.5-д заасан эрх бүхий байгууллагаас ажиглагч, сэтгүүлчид үнэмлэх олгохдоо хууль тогтоомжид заасан эрх, үүргийг танилцуулна.

### **Дөрөв. Санал авах ажиллагааг ажиглах, сурвалжлах**

4.1. Ажиглагч, сэтгүүлчийг энэ журмын дагуу олгосон үнэмлэхээр санал авах байранд нэвтрүүлнэ. Орчуулагчийг бүртгэлийн дагуу ажиглагч, эсхүл сэтгүүлчийн хамт нэвтрүүлнэ.

4.2. Санал асуулгыг ажиглах, сурвалжлах үед ажиглагч, сэтгүүлч, түүний орчуулагч нь үнэмлэхээ бусдад харагдахуйц байдлаар энгэртээ зүүсэн байна.

4.3. Ажиглагч, сэтгүүлч, түүнийг томилсон байгууллага нь санал асуулгыг ажиглах, сурвалжлахтай холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

4.4. Сонгуулийн байгууллага нь ажиглагч, сурвалжлагчийг сонгуулийн хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу эрхээ эдлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

4.5. Санал авах байрны багтаамжаас хамаарч бүх ажиглагч, сурвалжлагч нэгэн зэрэг ажиллах боломжгүй бол Хэсгийн хороо тэдгээрийг ээлжээр ажиллах боломжоор хангана.

### **Тав. Хяналт, хариуцлага**

5.1. Санал асуулгыг ажиглах, сурвалжлах ажиллагаанд дараах журмаар хяналт тавина:

5.1.1. гадаадын ажиглагч, сэтгүүлчийн үйл ажиллагаа сонгуулийн хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд Сонгуулийн ерөнхий хороо;

5.1.2.санал авах ажиллагааг ажиллах, сурвалжлах үеийн хяналтыг Хэсгийн хорооны дарга, гишүүн.

5.2.Энэ журмын 3.2.3-т заасан шаардлагыг биелүүлээгүй, 3.3, 3.4-т заасан үүрэг, хориглолтыг зөрчсөн ажиглагч, сэтгүүлч, түүний орчуулагчийн үйл ажиллагааг зогсоож, санал авах байрнаас гаргана.

5.3.Энэ журмын 5.2-т заасан зөрчил гаргасан ажиглагч, сэтгүүлч, түүний, орчуулагчийн үнэмлэхийг хураан авч, бүртгэлийг хүчингүй болгоно.

5.4.Ажиглагч, сэтгүүлчийн бүртгэлийг хүчингүй болгосон талаар түүнийг томилсон байгууллагад даруй мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд тухайн байгууллага ажиглагч, сэтгүүлчийг нөхөн томилохгүй.

5.5.Энэ журмын 5.3-т заасны дагуу ажиглагч, сэтгүүлч, түүний орчуулагчийн бүртгэлийг хүчингүй болгосон нь түүнийг холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 4 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 26/10

Улаанбаатар  
хот

### **МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДУУЛАХ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VII хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1. Дүүргийн нутаг дэвсгэрт мөрдөгдөх малын тоо толгойн албан татварын хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Малын тоо толгойд ногдуулах албан татварыг дүүргийн төсвийн орлогод төвлөрүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д дүүрэг болгосугай.

3. Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд өөрчлөлт оруулахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ф.МӨНХГЭРЭЛ

*Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2026 оны 4 дүгээр сарын 17-ны  
өдрийн 26/10 дугаар тогтоолын хавсралт*

**НЭГ. МАЛЫН НЭГ ТОО ТОЛГОЙД ТУХАЙН ТАТВАРЫН ЖИЛД  
НОГДУУЛАХ АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ**

№	Малын төрөл	Татварын хувь хэмжээ
1	Тэмээ	1000
2	Адуу	1000
3	Үхэр	1000
4	Хонь	300
5	Ямаа	500

**ХОЁР. ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ 0 БАЙХ МАЛЫН ТОО**

№	Малын төрөл	Малын тоо
1	Тэмээ	1
2	Адуу	1
3	Үхэр	1
4	Хонь	10
5	Ямаа	10

**ДОРНОГОВЬ АЙМАГ**  
**МАНДАХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2026 оны 4 дүгээр  
сарын 10-ны өдөр

Дугаар 04

Төхөм

**ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ**  
**ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.12 дахь заалт, Захиргааны Ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Сумын хэмжээнд мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ”-г нэгдүгээр, “Ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ачиж буулгах зардлын нэгж тариф”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд хэвлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Төлбөрийг бүрэн төвлөрүүлж, сумын хог хаягдлын менежментийг сайжруулах ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга (Б. Шижир)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2/12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

П. БАТХҮҮ

**Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн  
04 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт**

**СУМЫН ХОГ ХАЯГДАЛ ГАРГАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

№	Хог хаягдал гаргагч эх үүсвэрүүд		Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ (төг)	
1	2		3	5	
1	Иргэн		Сард	300	
2	Төсөвт байгууллага, аж ауйн нэгж	5 хүртэлх хүнтэй	Сард	20,000	
		5-20 хүртэлх хүнтэй			
		20-оос дээш хүнтэй			
3	Зочид буудал		Сард	10,000	
4	Үйлчилгээний газар	Цайны газар	Сард	15,000	
		Авто засвар			
		Үсчин, гутал завсар, оёдол			
		Ресторан, бар, кафе			
5	Худалдааны газар	Зах	Сард	20,000	
		Бөөний худалдааны төв			
		Дэлгүүр /архины зөвшөөрөлтэй/			
		Дэлгүүр / архины зөвшөөрөлгүй	Сард	15,000	
		Барилгын материал, барааны дэлгүүр			
		Жижиг худалдаа ТҮЦ, үүнтэй дүйцэх жижиг худалдаа			
6	Үйлдвэрийн газар	Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа компани	Сард	500 хүртэлх хүнтэй	300,000
				501-аас их хүнтэй	400,000
		Хээрийн түр кемп, зам анги, авто тээврийн компани		200,000	
		Уул уурхайн хайгуулын үйл ажиллагаа явуулж буй байгаа компани		50 хүртэлх хүнтэй	200,000
				51-аас дээш хүнтэй	250,000
		Тэсрэх бодис, баяжуулах үйлдвэр		200,000	
		Жижиг цехүүд		Үйлчилгээний газарт нэгтгэх	

7	Баяр наадам, нийтийн цуглаан, цэнгээт арга хэмжээ зохион байгуулагч	Үйл ажиллагаа явуулсан сард	20,000
8	Төмөр замын өөртөө, уул уурхайн ачилт буулгалтын талбай	Сард	400,000
9	Шатахуун түгээх станц	Сард	20,000

*Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн  
04 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**АХУЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ ТЭЭВЭРЛЭХ, АЧИЖ БУУЛГАХ  
ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ**

№	Хог хаягдлын хэмжээ	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ(төг)
0	1	2	3
1	Нэг пошик хог тээвэрлэх	100кг	4,000
		200кг	8,000
2	Нэг бункер хог тээвэрлэх	500кг	25,000

